



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/06

Биндэр сум

Агаар бохирдуулах эх үүсвэрийн
нэгдсэн тоо бүртгэл зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дах заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх журам, аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн Агаар бохирдуулах эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай А/713 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд Агаарын эх үүсвэрийн нэгдсэн бүртгэл зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Отгонбаяр (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга - Б.Гүндалай (Байгаль орчны мэргэжилтэн)

Гишүүд:

- Н.Болор-Эрдэнэ (Байгаль хамгаалагч)
- Т.Нарангарав (Байгаль хамгаалагч)
- Н.Энхманлай (Байгаль хамгаалагч)
- Н.Болормаа (1-р багийн Засаг дарга)
- Э.Мөнгөншагай (2-р багийн Засаг дарга)
- Ж.Ганзоригт (3-р багийн Засаг дарга)
- Х.Амарзаяа (4-р багийн Засаг дарга)
- Б.Тунгалаг (5-р багийн Засаг дарга)
- Ч.Болормаа (Цаг уурын өртөөний техникч)

2.Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг нутаг дэвсгэрийн хэмжээнд холбогдох журам, зааврын дагуу зохион байгуулж, дүнг аймгийн ажлын хэсэгт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (М.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.ДЭМБЭРЭЛСАЙХАН